

Бага боловсролын “Хүн ба байгаль”-ийн бие даан суралцах ажлын дэвтрийн хариултын хуудас

Бүлэг сэдэв: **Эх дэлхий**

Дэд сэдэв: **Голдож зэргэд-1**

Анги: **5 дугаар анги**

1. Сэргээн санах	1 Зөв тохируулан холбоорой. Дэлхийн хэлбэр хэмжээг багасган үзүүлсэн загвар Дэлхийн гадаргыг хавтгайд (цаасан дээр) буулгасан зураг	
2. Ойлгох	2 Дэлхийн загварт хаана юу байгааг гүйцээж тэмдэглээрэй. Хойд туйл Хуурай газар ус Тэнхлэг Өмнөд туйл Нөхөх үгс: хуурай газар, ус, хойд туйл, өмнөд туйл	
3. Ойлгох	Хуурай газар: А,В,С,D,E,F Далай: Н,I,J,K,L,	
4. Хэрэглэх	Дэлхийн гадаргыг өөр өөр хэлбэрээр дүрсэлсэн гэдгийг өөрийн үгээр тайлбарлана	

Бүлэг сэдэв: **Эх дэлхий**

Дэд сэдэв: **Голдож зэргэд-2**


Анги: **5 дугаар анги**

1. Ойлгох	Дэлхийн хэлбэр хэмжээг багасган үзүүлсэн загварыг , глобус гэнэ. Дэлхийн гадаргыг тусгаг ашиглан хавтгайд (цаасан дээр) буулгасныг газарзүйн зураг гэнэ. Дэлхийн гадаргын зөвхөн нэг тал нь бидний нүдэнд ил харагдаж нөгөө тал глобусын цаад талд байдаг тул харагдахгүй. Глобусыг хуваасан хоёр тал бөмбөрцгийг цаасан дээр буулгаж дүрсэлсэн зургийг тал бөмбөрцгийн карт гэнэ.	
2. Задлан шинжлэх	тал бөмбөрцгийн карт газарзүйн зураг	
3. Үнэлэх	Ус ба хуурай газар хэрхэн харагдахыг бичлэгээс үзээрэй. https://youtu.be/KDosftdo0rY	

Бүлэг сэдэв: **Эх дэлхий**

Дэд сэдэв: **Цэгийн байрлал-1**

Анги: **5 дугаар анги**

1. Ойлгох	 Голдож гэдэг нь дэлхийн бөмбөрцөг дээрх хойд өмнөд туйлыг холбосон, газарзүйн зураг дээр босоо татагдсан шугамыг хэлнэ. Зэргэд гэдэг нь дэлхийн бөмбөрцөг дээрх хөндлөн цагираг, газарзүйн зураг дээр хөндлөн татагдсан шугамыг хэлнэ. 	
2. Хэрэглэх	Глобус дээрх эдгээр босоо шугамууд тэнцүү биш, глобус дээрх хөндлөн цагирагууд бүгд хоорондоо ижил урттай биш гэдгийг туршилтаар илрүүлж, дүгнэлт гаргана.	
3. Хэрэглэх		

Бүлэг сэдэв: **Эх дэлхий**

Дэд сэдэв: **Цэгийн байрлал-2**

Анги: **5 дугаар анги**

1. Хэрэглэх

Баруун хагас

Энэ хагаст ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____



Зүүн хагас

Энэ хагаст ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____



Баруун зүүн хагаст ямар эх газар, далай оршиж байгааг бодож, хуурай газраас ус илүү гэдгийг гаргаж бичнэ. Магадгүй цэнхэр өнгөөр далай тэнгисийн тэмдэглэдэг. Цэнхэр өнгө их учраас гэж бичих хүүхэд бий. Гэтэл хуваасан хэсгүүдийг тооцоолж их багыг тооцоолох санаа гаргасан байж болно.

2. Хэрэглэх

Хойд хагас

Энэ хэсэгт ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____



Өмнөд хагас

Энэ хэсэгт ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____



Австрали, Антарктид нь өмнөд хэсэгт, хойд хэсэгт нь хойд Америк бүрэн оршдог гэдгийг ойлгож илэрхийлэх чухал.

3. Задлан шинжлэх

	Баруун	Зүүн	Хойд	Өмнөд	Дэлхийн аль хагаст оршдог вэ?
Монгол		✓	✓		Дэлхийн зүүн хойд хагаст оршдог.
Австрали		✓		✓	Дэлхийн зүүн өмнөд хагаст оршдог.
Америкийн нэгдсэн улс	✓		✓		Дэлхийн баруун хойд хагаст оршдог.